



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 5/36

Ховд

Я.Ганзоригийг ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 05/19037 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Ядмаагийн Ганзоригийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн “Шим-Ус” ОНӨААТҮГ-ын даргаар томилсугай.

2. Я.Ганзоригийн үндсэн цалинг 2,930,000 төгрөгөөр тооцон цалинжуулж, хууль тогтоомжид заасан холбогдох нэмэгдлүүдийг сар бүр бодож олгохыг “Шим-Ус” ОНӨААТҮГ-ын ерөнхий нягтлан бодогч (Ч.Даваадорж)-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрд тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Я.Ганзоригт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА

8400001 2300

Zah B/36 Ba

Засаг даргын 2024 оны  
11 дүгээр сарын 27-ны өдрийн  
Б/35 дугаар захирамжийн хавсралт

## АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Түмэнжаргал (Орон нутгийн өмчийн газрын ахлах  
мэргэжилтэн)

Гишүүд: Ч.Даваадорж (“Шим-Ус” ОНӨААТҮГ-ын ерөнхий  
нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэбат (Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

-оOо-